

МОНГОЛ ХЭЛНИЙ ЗҮЙРЛЭЛИЙН УНАГАН ДАРХЛАА,
ЖИШИГ ХЭМЖҮҮР

Д.Бадамдорж


Түлхүүр үг: зүйрлэл, унаган дархлаа, жишиг хэмжүүр, хэл, сэтгэхүй, танин мэдэхүй

Хэлний зүйрлэл гэдэг бол аливаа нэг юм, үзэгдлийн шинжийг нөгөө юм, үзэгдлийн төстэй шинжтэй жишиж дүрслэх тархины үйл хөдөлгөөн юм. Монголчууд “Зүйргүй үг байдаггүй, Зүйдэлгүй дээл байдаггүй” хэмээн хэлэлцдэг. Аман хийгээд бичгийн хэлнээ зүйрлэл элбэг байгааг монгол утга зохиолоос мэдэж болно. Үүнийг нарийвчлан ажиглавал, **нийлэмж үг, нийлмэл үг, өвөрмөц хэлц** гэх мэт нийлцэд зүйрлэл цөөнгүй байдаг.

Ж.Төмөрцэрэн “. . . Хэлний зүйрлэл бол толь бичигт тэмдэглэгдэх бөгөөд уран зохиолын зүйрлэл бол толь бичигт орохгүй” (2001:31) хэмээн бичсэнээс үзвэл, хэлний зүйрлэл нэлээд хураангуй, цомхон байх учиртай. Монгол хэлний зүйрлэлийг нарийвчлан судлахад зүйрлэгдэхүүн буюу **эх** ухагдахуун, зүйрлэхүүн буюу **эцэг** ухагдахуун, зүйрлэл буюу **хүү** ухагдахууныг сэтгэхүй, хэл, танин мэдэхүй, соёл гэх дөрвөн талаас нь танин мэдүүштэй юм. Хүний сэтгэхүйн эрчим, сэтгэлгээний үнэлэмжийн бүтээгдэхүүн бол зүйрлэл юм. Хүний хэлний хэл зүй-үгийн сангийн зарим нэгжийн бүрэлдэхүүнд буй зүйрлэлийг нарийвчлан авч үзье.

А. Нийлэмж үгээр бүтсэн зүйрлэл:


Хүний хэлний захирах захирагдах холбоогоор бүтсэн, тодотгол тодотгуулагчийн харилцаатай нийлц (синтагма)-ээр сэтгэж жишсэн сэтгэмжит зүйрлэл байдаг. Жишээ нь: *Хавирган сар, сэмжин үүл, сэлмэн эвэр, мөнгөн сар, хурган мөөг, тараган цавуу, өөхөн чулуу, элгэн чулуу, ул боов, морин тогоо, олгой нуур, хуруу шил, үзмэн хүрэн, цасан цагаан, чонон саарал, шалан шар, ангир шар, хулсан шар, зүлгэн ногоон, номин цэнхэр, унаган нутаг, унаган морь, унаган ааш, морин давалгаа, хонин давалгаа, морин зэрэглээ, хонин зэрэглээ* гэх мэт. Ийнхүү нийлэмж үгээр тогтсон зүйрлэл бол төдийлөн нэршин хэвшээгүйвтэр байдаг. Зураглавал:



Нийлэмж үгээр бүтсэн зүйрлэл нь утга зохиолд үлэмж хэрэглээ, давтамжтай байдаг.


Б. Нийлмэл үгээр бүтсэн зүйрлэл

Хэд хэдэн үг, үглэвэр нэгдэж, нэгэн ухагдахуун илэрхийлж буй нийлмэл нийлцийн сэтгэмжээр буй болсон зүйрлэл юм. Утга хэлбэр нь барьцалдан хэвшсэн учраас нэр томьёо, нийлмэл нэр болсон онцлогтой юм. Жишээ нь: *Нохой хуш, нохой зээх, морин шарилж, хонин шарилж, хонин арц, ямаан арц, хүн чулуу, хүн орхойдой, үхрийн нүд, нохойн хошуу, тарваган шийргэх мэт нэр томьёо голдуу нийлмэл үгээр бүтсэн байна. Харин оноосон нэрийн бүрэлдэхүүнд Дэл хад, Майхан толгой, Мэлхий хад Могой хад, Зүрх уул, Олгой нуур. . .* гэх мэт цөөн бий. Хүн, амьтан, ургамлын нэрийг ажиглаваас **эх** ухагдахуун болсон хүн, амьтан, ургамлын тухай ухагдахуун нь зүйрлэгдэхүүн буюу дэвсгэр болж, тэдгээртэй төсөөтэй жишиж болох өөр аливаа нэр нь **эцэг** ухагдахуун буюу зүйрлэхүүн болж, ингээд **хүү** ухагдахуун буюу зүйрлэл болно гэж бодож байна. Нийлмэл үгээр бүтсэн зүйрлэл бол ихээхэн нэршин хэвшсэн нэгж зүйлийг нэрлэсэн шинж бүхий байна. Зураглавал:



В. Өвөрмөц хэлцээр бүтсэн зүйрлэл


Үгийн утга шилжүүлэн хийсвэрлэн, өвөрмөц хэлц үүсгэхдээ монгол унаган сэтгэхүйгээр жишсэн ухааралтай бүрэлдэхүүндээ зүйрлэл багтаасан өвөрмөц хэлц цөөнгүй бүтээсэн байна. Жишээ нь: *Хоёр зээрдээрээ* ирлээ. Хоёр зээрд = хоёр хөл хэмээх зүйрлэл (адилтгал) юм. *Алтан гартай, чулуун зүрх, туулай зүрхтэй, үхрийн бөөр шиг, хөгишин чоно, хашир хандгай, хөгишин бурхи, алтан хошуулах, зэс хошуулах, хагархай хэнгэрэг (чалчаа), салхин дэвүүр, цаасан дарцаг, туулай шиг, үнэг шиг, хонь шиг, чоно шиг, тэмээ шиг, ямаа шиг, үхэр шиг, ямаан зан, ямаан омог* гэх мэт. Энэ мэт өвөрмөц хэлцийн утгыг нарийвчлан үзвэл, зүйрлэл болох нь илэрхий болдог юм. Монгол хэлний өвөрмөц хэлцийн сэтгэж хэлсэн ухаарал бол гүн бүтцийн хувьд үгийн утга шилжүүлэнгээ нэг зүйл юмыг нөгөө зүйл юмтай онцгой шинжээр нь жишиж зүйрлэсэн байдаг ажээ. Зураглавал:



Г. Өгүүлбэрээр бүтсэн зүйрлэл

Монгол хүний сэтгэхүйн үйл, тархины хэлний илэрхийлэх онцлогоор бүтэн өгүүлбэрээр **эх** зүйрлэгдэхүүн, **эцэг** зүйрлэхүүн нь бүхэл бүтэн бодомжоор буюу өгүүлбэрээр бүтэх томоохон нийлмэл бүтцээр илэрч буй зүйрлэл байна. Жишээ нь: Монгол хэлний *шиг, мэт, адил, өөрцгүй, чинээ, -рхуу, -рхүү* зэрэг илтгэгч, холбогч, зааглагчтай зүйрлэл бүхэн өгүүлбэрээр бүтэж байна. Ихэвчлэн далд адилтгал юм. Жишээ нь: *Яргуй хөөсөн ямаа шиг. . , үлий сахисан сар шиг. . , үнээ дагасан бух шиг. . , Шог үг шор мэт, Хатуу үг хад мэт* гэх мэт. Ийм зүйрлэлийг өгүүлбэр зүйн түвшинд хэлэлцэх шаардлагатай юм.

Зураглавал:




Ийм зүйрлэл монгол хэлний зүйрлэлийн жишиг хэмжүүр болж чадахгүй гэж бид үзэж байгаа.

Монгол хэлний зүйрлэлийн монгол төрөлх сэтгэхүйгээр үүдсэн унаган дархлаа, шигшсэн жишиг хэмжүүр (etalon) бол 1. Нийлэмж үг, 2. Нийлмэл үг, 3. Өвөрмөц хэлц бүтцийн дотор байна. Бид хэдэн жилийн өмнө “Монгол хэлний зүйрлэлийн жишиг хэмжүүр нь хоёр үглэврийн утгын хүрээнд байгаа билээ. Чингэвэл: Морин чулуу, морин тогоо, азарган дөш, хонин тогоо, хонин чулуу, хурган үүл, хурган мөөг гэх мэтэс бол яригч, сонгсогч, оролцогч нарт ойлгомжтой, үнэлэмжтэй байна. Бүдүүвчилбэл:

Зүйрлэх бүтэц:	Зүйрлэхүүн	+	зүйрлэгдэхүүн	=	зүйрлэл
Зүйрлэх нийлц:	Морин чулуу	⇐	морин	⇒	чулуу
Утга нь:	(өндөр, том)		(том, өндөр)		(том - том)


гэх мэт” (Бадамдорж Д. 2018:22) хэмээн бичиж байсан билээ. Зүйрлэлийн утга бол хосолмол төсөөтэй байхын хамт утгазүй-үгийн сан судлалын судлагдахуун юм. Н.Нансалмаа нар “Зүйрлэл бол хүний танин мэдэх, сэтгэн бодох үндсэн арга” (2014:142) гэж үзсэн явдал бидний энэхүү зүйрлэхүүн, зүйрлэгдэхүүн гэсэн хос ухаарлаар зүйрлэл бүтээх замыг онож хэлсэн байна. Бүрдүүлбэр утга зүйн (компонентная семантика) үүднээс хэлний зүйрлэлийн гүн бүтцийг ажиглавал, утганцар, утгалбар, утгын шүтэлцээ нь хүний тархины бор гадаргад болж буй сэтгэхүйн нарийн үйл хөдөлгөөн учраас дэс дараа, уялдаа хамаарал, төстэй шинжийн жишил гэх зэрэг нь учир зүйтэй байна. Зураглавал:



Эхлээд цавууны цагаан, шингэн шинжийг танин мэдээд, дараа нь түүнтэй ижил төстэй шинж бүхий тарагийг танин мэдсэний үндсэн дээр хүний сэтгэх үйл ихэд оролцсон энэхүү ЗҮЙРЛЭЛ бүтсэн учир танин мэдэхүйн утга зүйн цөм судлагдахуун нь болдог байна. Ж.Баянсан “Метафорыг бүтээх оньс нь сэтгэлгээний тогвортой хэв шинж (stereotype)-ийг тодорхойлохын тулд сэтгэлгээний жишиг хэмжүүр (etalon) гэх мэт мета хэлийг ашиглахаас өөр аргагүй болно” (2016:26) гэж үзсэн байна. Бид монгол хэлний зүйрлэлийн унаган дархлаа, жишиг хэмжүүр нь хоёр үглэврийн хүрээнд тогтсон байна гэж үзэж, энэхүү хэлний доторх хэлийг шинжлэв. Жишээ нь:

Монгол хэлний МОРИН, ХОНИН хэмээх хоёр үгээр зүйрлэн хэлэх монгол сэтгэхүйн өвөрмөц онцлог нь маш эртний үүсэл хэрэглээтэй байгаа нь амьтан, ургамал, юмсын нэрийн зүйлээс тодорхой мэдэгдэж байна. Эл хоёр үгийн хэрэглээний байдлаас үзвэл, МОРИН гэхээр том, өндөр, шим чанар сайнгүй, ХОНИН гэхээр бага, нам, шим чанар сайтай гэсэн утга илт мэдэгдэж байгаа онцлогтой байна. Ш.Гаадамба “Зүйрлэл бол ерөөс нэг юмын шинж чанарыг өөр адил төсөөт юмын мэдэгдэж байгаа шинжээр дамжуулж илтгэн дүрслэх тул хоёр юм бие биеэ илтгэнэ” (1989:125) гэж зүйрлэхүүн, зүйрлэгдэхүүний утгын зохицлыг бичжээ.

Тухайлбал: Эл хоёр үгээр бүтсэн зүйрлэгдэхүүн, зүйрлэхүүний харилцаагаар зүйрлэлийг зэрэгцүүлэн үзье. Зураглал:



Ийм монгол хүний тархины хэлнээ их бага хэмжээсийн үйл хөдөлгөөн болсоор иржээ. А.Цог-Очир “Танин мэдэхүйн хэл шинжлэлийн суурь судалгааны нэн чухал асуудал бол зүйрлэлийн танин мэдэхүйн онол юм” (2016) хэмээн үзсэнчлэн монгол хэлний зүйрлэлийг гүнзгий судлах хэрэгтэй бөгөөд сүүлийн үед судалгаа хийгдсээр л байгаа юм.

Монгол сэтгэлгээний үүднээс хэлний зүйрлэлийн унаган дархлаа, жишиг хэмжүүр нь нийлэмж үг, нийлмэл үг, өвөрмөц хэлцийн **мэдлэгийн долгион (квант знания)**. Маслова А.В. 2008:50) бөгөөд сэтгэн бодож, жишин харьцуулж дүрсэлсэн ухаарал нь өөр хоорондоо **харилцан төсөөтэй** шинжийн тогтсон загвартай байна. Тухайлбал:

А нь амьтай, Б нь амьгүй хэмээх болзмол тэмдэг хэрэглэвээс, доорх загвараар зүйрлэдэг юм байна.

Загвар нь: Жишээ нь:

А		А үхэр хэдгэнэ, үхэр огдой, нохой зээх, морин тарвага, хонин гүрвэл.
А		Б шалзан хадаас, азарган дөш, ингэн туйлаадас, хурган мөөг, нохой хуш.
Б		А шанаган хорхой, төмөр сүрэг, салхин зээрд, суман могой, яндан морь.
Б		Б тарган цавуу, дэл хад, хазаар өвс, хөмсгөн сар, чөдөр өвс, мөөгөн үүл.

Эл загвараар бүтсэн зүйрлэл нь шинжлэх ухааны нэр томьёо, нийлмэл үг, нийлэмж үг зэргээр зонхилон бүтсэн байх агаад бичгийн хэлнээ хэрэглээ их, давтамжтай, унаган дархлаа тогтсон байдаг ажээ.

Монгол хэлний зүйрлэл бол үе үеийн монголчууд тулж мэдрээд, хийсвэрлэн сэтгэж, аман хийгээд бичгийн хэлнээ дархлан бэлэглэсэн хэлний илэрхийлэл, танин мэдэхүйн утга зүй буюу монгол сэтгэлгээний цөм сэтгэмж учраас байгаль, нийгмийн юм, үзэгдэл, хөдөлгөөн, хүний сэтгэхүйн үйл нь уран дүрслэлээр тархинаа туссан тусгал ч юм. Ийм учраас л аливаа бодитой ба хийсвэр юмын тодорхой шинжийг танин мэдэж, гүйх ухаан зарсан харьцуулал болох нь илэрхий. Т.Пагва “Аливаа юмын өнгө дүрс, хэлбэр маяг, байж байгаа байдлаар нь зүйрлэн нэрлэхийг метафор гэнэ” (1959:93) гэж тодорхойлсон юм. Монгол туургатны сэтгэхүйн эрчим, сэтгэлгээний үнэлэмж шингэж хурсан хур мэдлэгийн бүтцийн орон (оногдохууны орон) (Полевая структура концепта. Попова Д.З., Стернин А.И. 2007:214) байдаг. Энэ нь монгол хэлний зүйрлэлийн ангилал юм. Үүнд:

Нэг. Өнгө зүсмийн зүйрлэл: Хүмүүний нүднээ өртөн тусах өнгө зүсмийн дотроос сэтгэн бодсоор сонголт хийж, ихэвчлэн бодит юмын өнгийг танин мэдсэн **мэдлэгээр** өнгө зүсмийг тодотгон илтгэсэн утгатай зүйрлэл бүтээдэг ажээ. Жишээ нь, **Ангир** шар, **алтан** шар, **үзмэн** хүрэн, **хөө** хар, **хилэн** хар, **элгэн** хүрэн, **зүлгэн** ногоон, **шаазгай** алаг, **цасан** цагаан, **дун** цагаан, **тараган** цагаан, **сүүн** цагаан, **сувдан** цагаан, **танан** цагаан, **өөхөн** цагаан, **хаш** цагаан, **мөнгөн** цагаан, **чандаган** цагаан, **лавай** сар, **алтан** шаргал, **номин** цэнхэр, **жимсэн** улаан, **шунхан** улаан, **шүрэн** улаан, **үүлэн** бор, **могой** хээр, **чонон** саарал, **үнэсэн** саарал, **зүлгэн** ногоон, **шүрэн** улаан, **хулсан** шар, **гал** улаан, **зандан** хүрэн, **цасан** хужир, **манхан** шарга, **хадган** цэнхэр, **цусан** зээрд гэх мэт.

Хоёр. Овор төрхийн зүйрлэл: Хүмүүн нүдээр мэдэрч, сүр барааг нь танин мэдээд, хоёр зүйл юмыг төрхөөр нь жишсэн мэдлэгээр зүйрлэл бүтээжээ. Жишээ нь: **Адуун** чулуу, **тэмээн** чулуу, **тэмээн** харгана, **үхэр** чулуу, **хонин** чулуу, **морин** тогоо, **хонин** тогоо, **морин** зэрэглээ, **хонин** зэрэглээ, **үхэр** буу, **гунан** буу, **үхэр** бүрээ, **үхэр** харгана, **морин** давалгаа, **хонин** давалгаа, **бууран** туйлаадас, **ингэн** туйлаадас, **хурган** үүл, **азарган** дөш, **бух** тэрэг, **бууран** тогоо, **тарваган** хүн, **морин** тарвага, **тугал** нүд, **дэрсэн** шилбэ, **азарган** бороо, **тулман** хөхт, **ууцан** сүүлт, **бухан** бяруу, **хурган** хуц, **ухнан** ишиг, **мэлхий** хаалга, **цээж** гэр гэх мэт. Бас хуруун чинээ, туулайн чинээ, шагайн чинээ, хумсын чинээ гэх мэтсийг багтааж болно.

Гурав. **Чанар шинжийн зүйрлэл:** Юмсын шинж чанарыг танин мэдээд, өөр хооронд нь харьцуулан жишиж, энэ мэдлэг дээрээ суурилж, зүйрлэл бүтээдэг ажээ, Жишээ нь: **Алтан** ураг, **цагаан** яс, **эр** ноос, **эм** ноос, **эр** дэгээ, **эм** дэгээ, **ахмад** чавхдас, **отгон** чавхдас, **унаган** морь, **унаган** нутаг, **баатар** хуйх, **ган** зориг, **алтан** амь, **алтан** сургаал, **зайдан** хаваржаа, **өвгөн** бенз, **торгон** ир, **торгон** элс, **торгон** сүрэг, **торгон** цэрэг, **төмөр** сүрэг, **салхин** зээрд, **шувуун** саарал, **хатан** зөгий, **яндан** морь, **наран** хайнаг, **саран** хайнаг, **усан** хайнаг, **махан** төмөр, **мөсөн** чихэр, **навч** өртөө, **ноён** оргил, **нохой** хүн, **уураг** сүүл, чамдаа **баавгай**, чамдаа **Жангар**, чамдаа **эр бар**, **нохой** ам, **цусан** чөмөг, **цусан** тамир, **янзаган** зоо, **усан** толгой, **гөлмөн** төмөр, **чулуун** зүрх, **элсэн** чихэр, **явган** шуурга, **явган** үлгэр гэх мэт.

Дөрөв. **Цаг хугацааны зүйрлэл:** Цаг хугацааг танин мэдсэн мэдлэгээрээ зүйрлэл бүтээдэг. Жишээ нь: **Өдөр** шиг шөнө, **үхэр** тэрэг шиг, **нүд** ирмэх зуур,

Тав. **Хэм хэмжээний зүйрлэл:** Байгаль, нийгмийн юмсын хэмжээ дамжааг танин мэдэн сэтгэж, зүйрлэл бүтээсэн байна. Жишээ нь: **Далай** лам, **далай** аварга, **амбан** шар, **ахмад** чавхдас, **отгон** чавхдас, **далай** хаан, ургацын **далай**, эрдмийн **далай**, шуналын **тулам**, **хүүхэн** ул, **хүүхэн** хэл, хуруун чинээ, алгын чинээ, шагайн чинээ, хумсын чинээ гэх мэт.

Зургаа. **Орон зайн зүйрлэл:** Орон зайн мэдлэгээр зүйрлэл бүтээнэ. Жишээ нь: **Гээг** өвс, **гээг** цэрэг, **гээг** ус, **сүмбэр** уул, **сүн** далай, **талын** чинээ, **уулын** чинээ, **жилийн** газар гэх мэт.

Долоо. **Хэлбэр дүрсийн зүйрлэл:** Юмсын гадаад хэлбэрийг ажиглаж танин мэдээд, төстэй хэлбэр дүрсийг жишиж бодон, зүйрлэл бүтээдэг. Жишээ нь: **Ул** боов, **таван салаа боов** өгөх, **дэл** хад, **мэлхий** хад, **майхан** толгой, **хуруу** шил, **хуруу** эвэр, **сэлмэн** эвэр, **сэмжин** үүл, **хавирган** сар, **загасан** талх, **могой** араа, **цэцэг** араа, **саран** боов, **ташуур** хорхой, **шанаган** хорхой, **малгай** гарчиг, **манх** тариа, **мөөгөн** үүл, **мэлхий** ааруул, **навчин** боорцог, **олгой** нуур, **өвдөг** газар, **суварган** мөс, **соёо** сахал, **навчинд /чих/** бараалхах, **нуман** жагсаал, **хялгасан** хорхой, гэх мэт.

Найм. **Бэлгэ чанарын зүйрлэл:** Монголчууд бэлгэдэн сэтгэж, өвөрмөц зүйрлэл бүтээсэн байна. Жишээ нь: **Удган** мод, **ээж** хад, **билгүүн** хээр морь, **өлзийт** өвс, **уянгат** мод, **дурсгал** цэцэг, **төлөгч** өвс, **цэцэн өвс**, **хараалч** цэцэг, **бэри** цэцэг, **баярт** мод, **билигт** өвс, **цагаан** сар, **цагаан** зам, **цагаан** салхи, **цагаан** бороо, **цагаан** сэтгэл, **цагаан** толгой, **хонины** хүү, **хонины** морь, **чөдрийн** ганц, **морин** хуур, **гарди** хуур, саваа **шандас**, ноос **мяндас** болог гэх мэт.

Ес. **Үйл хөдлөлийн зүйрлэл:** Зарим үйл хөдөлгөөнийг гярхай мэдэж, зүйрлэл бүтээжээ. Жишээ нь: **Үнэгчлэн** унтах, **туулайчлан** явах, **бурханчлан** тахих, **сүвэгчлэн** хайх, **чулуудан** хаях, **малгайлан** орох, **дэлхий дэлэгнэх**, **бургас гөлөглөх**, хараал **урсгах**, **ус олгойдох**, **баавгайчлан** давамгайлах, **шүхэрлэн** дэлгэх, шалгалтад **унах**, **сэрсэн** тал, ишгэн цагаан үүл хур **дуудан майлна** гэх мэт.

Алена Оберфалзерова монгол хэлний үйл үгээр бүтсэн зүйрлэлийг тодруулж, дэлхий дэлэгнэх, бургас гөлөглөх, ногоо соёолох, хараал урсгах, чулуу хөөлгөх, хүүхэд олдох, хүүхэд хөлсөх (Алена. 2006) гэх зэрэг үйл үг бол утга шилжин зүйрлэсэн болохыг тэмдэглэсэн нь сонирхол татаж байна. Мөн И.П.Сусов “Характеризующая функция метафор наиболее явно проявляется у глаголов. Время – бежит. Мысли – текут. Совесть – грызёт” [Зүйрлэлийн онцгойрох үүрэг нь үйл үгнээ илүү тод илэрдэг. Цаг хугацаа - харвасан сум шиг одсоор. Санаа – ус шиг урссаар. Нинжин сэтгэл – нохой шиг хэмлэлдсээр] (2007:119) гэж үйл үгээр бүтэх зүйрлэлийг онцлон бичжээ. Харин одоогоор монгол хэлний үйл үгийн зүйрлэлийг хараахан судлаадүй байна.


Арав. **Ёс заншлын зүйрлэл:** Монгол ёс заншлын холбогдолтой мэдлэгт суурилсан зүйрлэл бий. Жишээ нь: **Цагаан сар** (монголчуудын уламжлалт баяр), **Эв мод** (**Эв мод гэдэг нь** Монгол-Оросын хилийн харуулын хүмүүс мэнд мэдээ хүргэх ба хилийн албаны хэргээр

авч очин эвийг нийлүүлэн үздэг итгэмжлэлийн тэмдэгт мод юм. Баталгаа гэсэн утгатай.) **Эв мод – Баталгаа. Баруун гар** (монголчууд баруун зүг, талыг дээдлэх ёс заншилтай учраас хамгийн дотно найз нөхрийг “баруун гар” хэмээн утга шилжүүлэн зүйрлэсэн байна). **Баруун гар – дотно нөхөр, Баянхангай** (Хүндэтгэн шүтэж, цайныхаа дээжийг өргөдөг газар орноо хангайн сайхан нутагтай жишиж, бахдан зүйрлэсэн байна.) **Баянхангай – газар нутаг** гэх мэт.

Арваннэг. **Хүний зан чанарын зүйрлэл:** Хүний зан чанарыг танин мэдээд, тохирох бусад амьтан ба юмын шинжээр зүйрлэдэг. Жишээ нь: **Нохой** зан, **ямаан** омог, **чонон** санаа, **үнэгэн** заль, **туулай** зүрх, **манж** зан, ааш гэж **адсага**, зан гэж **зараа** гэх мэт.

Арванхоёр. **Хий үзэгдлийн зүйрлэл:** Хийсвэрлэн сэтгэж, зүйрлэл бүтээсэн байна. Жишээ нь: **Чөтгөр** бөөс, **чөтгөр** хорхой, **чөтгөрийн** гал, **чөтгөр шиг** амьтан, **чөтгөр** тогтох аргагүй, гэрийн **буг** болох, эмгэн **шулам** гэх мэт.

Монгол хэлний зүйрлэлийн орныг зураглавал:



Дүгнэн хэлбэл, монгол хэлний нийлэмж үг, нийлмэл үг, өвөрмөц хэлц зэргийн бүрдүүлбэрт буй зүйрлэл бол бидний хэлний зүйрлэлийн унаган дархлаа (immunity), жишиг хэмжүүр (etalon) юм.

ABSTRACT

In this article, the author said as following that in the collocations, compounds and idioms of Mongolian language there are metaphors. This is the Mongolian language etalon and immunity. For example: Morin togoo - horse pot. Its meaning is big pot. Metaphor has traditionally been viewed as the most important form of figurative language use, and is usually seen as reaching its most sophisticated forms in literary or poetic language.

Номзүй

- Alena Oberfalzerova.** 2006. *Metaphors and Nomads*. Charles University. pp. 46-85.
- Бадамдорж Д.** 2018. *Танин мэдэхүйн утга зүйн удиртгал*. Уб.
- Баянсан Ж.** 2016. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб.
- Гаадамба Ш.** 1989. *Утга зохиолын онолын үндэс*. Уб.
- Маслова А.В.** 2008. *Когнитивная лингвистика*. Минск.
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг*. 2008. Таван боть. Уб.
- Нансалмаа Н., Долгор С.** 2014. *Танихуйн хэл шинжлэл*. Уб.
- Пагва Т.** 1959. *Хэлний шинжлэлийн удиртгал*. Уб.
- Попова Д.З., Стернин А.И.** 2007. *Когнитивная лингвистика*. М.,
- John I. Saeed.** *Semantics*. 1997. Trinity College Dublin. Blackwell publishers.
- Сусов П.И.** 2007. *Введение в языкознание*. Золотая серия. Москва.
- Төмөрцэрэн Ж.** 2001. *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб.
- Цог-Очир А.** 2016. *Зүйрлэлийн танин мэдэхүйн онол*. Монгол судлалын чуулган. Уб., №21 (56).